



Захиргааны хэмжээний  
актын улсын нэгдсэн санд  
2020 оны 01 сарын 24-ны  
одрийн 166 дугаар түүрээс

## ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 12 сарын 30 өдөр

Дугаар A/259

Улаанбаатар хот

### Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2 дахь хэсэг, Татварын ерөнхий хуулийн 77 дугаар зүйлийн 77.7.3 дахь хэсэг, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- “Татварын хялбаршуулсан горим ашиглах татвар төлөгчийн хүсэлтийг бүртгэх, шийдвэрлэх, бүртгэлээс хасах журам”-ыг баталсугай.
- Журмын хэрэгжилтийг хангаж, хавсралтаар батлагдсан маягтыг цахим татварын системд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Татвар төлөгчтэй харилцах газар /Д.Цогзолмаа/, Мэдээллийн технологи, статистикийн төв /Х.Батбаяр/-д тус тус даалгасугай.

ДАРГА

Б.ЗАЯАБАЛ

Бүртгэлийн дугаар ..20.....

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ  
ГАЗАР

ХУУЛБАР ҮНЭН

Хуулбар олгосоо ажилтны гарын

2019 оны 12 сарын 30-ний өдөр

Татварын ерөнхий газрын даргын  
2019 оны 12 сарын 30 өдрийн  
16259 дүгээр тушаалын хавсралт

## ТАТВАРЫН ХЯЛБАРШУУЛСАН ГОРИМ АШИГЛАХ ТАТВАР ТӨЛӨГЧИЙН ХҮСЭЛТИЙГ БҮРТГЭХ, ШИЙДВЭРЛЭХ, БҮРТГЭЛЭЭС ХАСАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь татварын алба, татвар төлөгч Татварын ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлд заасан татварын хялбаршуулсан горим /цаашид "хялбаршуулсан горим"/-ыг ашиглах үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 29 дүгээр зүйл, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 15.6-д заасан хялбаршуулсан горим ашиглах татвар төлөгчийн хүсэлтийг бүртгэх, шийдвэрлэх, бүртгэлээс хасахтай холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.3. Хялбаршуулсан горим ашиглах татвар төлөгч нь Татварын ерөнхий хуулийн 11.2-т заасны дагуу татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан /цаашид "ТБМНС" гэх/-д холбогдсон байна.

1.4. Татварын ерөнхий хуулийн 11.3-т заасны дагуу хялбаршуулсан горимыг зөвхөн татварын жилээр тооцох бөгөөд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 29.6, 29.7-д зааснаас бусад тохиолдолд тухайн татварын жилийн дундуур уг горимоос гарахгүй.

### Хоёр. Татварын хялбаршуулсан горим ашиглах татвар төлөгчийн хүсэлтийг бүртгэх, шийдвэрлэх

2.1. Албан татвар төлөгч хялбаршуулсан горим ашиглах хүсэлтийг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 29.1-д зааснаар тухайн татварын жилийн 3 дугаар улиралд, хувь хүн тухайн татварын жилд багтаан "Татварын хялбаршуулсан горим ашиглах хүсэлт"-ийн маягтаар харьяалах татварын албанад хүргүүлнэ.

2.2. Татварын алба нь энэ журмын 2.1-д заасан хүсэлтийг бүртгэхдээ ажлын 10 хоногт багтаан дараах шаардлага хангасан эсэхийг хянана:

2.2.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 29.1, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 15.6-д заасан өмнөх жилийн тайлангаар баталгаажсан борлуулалтын нийт орлогын хэмжээ 50.0 сая төгрөгөөс бага;

2.2.2. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 29.3.2-т зааснаас бусад үйл ажиллагаа эрхэлдэг;

2.2.3. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 29.3.1, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 15.7-д заасан нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгэгдээгүй;


2.2.4. Энэ журмын 1.3-т заасны дагуу бүртгэгдсэн.

2.3. Энэ журмын 2.2-т заасан шаардлагыг хангасан тохиолдолд татвар төлөгчийн харьяалах татварын албаны татвар төлөгчтэй харилцах нэгж татвар төлөгчийн хүсэлтийг бүртгэх асуудлыг шийдвэрлэж тухайн татвар төлөгчид мэдэгдэнэ.

2.4. Татварын алба хялбаршуулсан горим ашиглах татвар төлөгчийн хүсэлтийг шийдвэрлэсэн тохиолдолд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

2.4.1. Татвар төлөгчийн хүсэлтийг бүртгэж, шийдвэрлэсэн тохиолдолд нэгдсэн дугаараар ТБМНС-д бүртгэнэ;

2.4.2. "Татварын хялбаршуулсан горим ашиглах татвар төлөгчөөр бүртгэх шийдвэрийн хуудас"-ыг баталгаажуулна;



2.4.3. албан татвар төлөгчийн гэрчилгээнд “ХГ” хялбаршуулсан горим гэсэн тэмдэглэгээ хийх;

2.4.4. ТБМНС-д татвар төлөгчийн тухайн татварын төрлийн бүртгэлд хялбаршуулсан горимыг бүртгэх.

2.5. Албан татвар төлөгч нь дараа оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн татварын хялбаршуулсан горим ашиглана.

2.6. Татварын алба татвар төлөгчийн хүсэлтийг хянаж, энэ журмын 2.2-т заасан шаардлага хангаагүй бол энэ тухай албан татвар төлөгчид мэдэгдэнэ.

#### **Гурав. Татварын хялбаршуулсан горимоос хасах**

3.1. Хялбаршуулсан горим ашиглаж байгаа албан татвар төлөгч дараах нөхцөл үүссэн тохиолдолд хялбаршуулсан горимоос хасагдах хүсэлтээ “Татварын хялбаршуулсан горимоос хасагдах хүсэлт”-ийн маягтаар харьяалах татварын албанд ирүүлнэ:

3.1.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 29.3.2-т заасан үйл ажиллагаа эрхэлж эхэлсэн өдрөөс;

3.1.2. Нэмэгдсэн өргтийн албан албан татварын тухай хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу нэмэгдсэн өргтийн албан татварын суутган төлөгч болсон өдрөөс;

3.1.3. татвар төлөгч өөрөө хүсэлт гаргасан.

3.2. Энэ журмын 3.1.1, 3.1.2-т заасан хүсэлтээ ирүүлээгүй тохиолдолд татварын алба тухайн албан татвар төлөгчийг хялбаршуулсан горимоос хасна.

3.3. Хялбаршуулсан горимоос хасагдах албан татвар төлөгчийн хүсэлтийг татварын алба хүлээн авч, ажлын 10 өдрийн дотор шийдвэрлэж, татвар төлөгчид мэдэгдэнэ.

3.4. Энэ журмын 3.1.3-т заасны дагуу хүсэлт гаргасан бол албан татвар төлөгч нь дараа оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хялбаршуулсан горимоос хасагдана.

3.5. Хялбаршуулсан горимоос хасагдах албан татвар төлөгчийн хүсэлтийг харьяалах татварын албаны татвар төлөгчтэй харилцах нэгжийн татварын улсын /ахлах/ байцаагч хянаж, “Татварын хялбаршуулсан горимын бүртгэлээс хасах шийдвэрийн хуудас”-ыг баталгаажуулан ТБМНС-д бүртгэнэ.

Бүртгэлийн дугаар .....	220
ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАРАР	
ХУУЛЬЧИДААСАН	
Хуулбар олгосон	
19 12 31	
20 ... оны ... сарын ...	



Татварын хялбаршуулсан горим ашиглах  
хүсэлтийг бүртгэх, шийдвэрлэх, бүртгээс  
хасах журмын 1. дүгээр хавсралт

## Монголын Татварын Алба

Маят ХГ-01

### ТАТВАРЫН ХЯЛБАРШУУЛСАН ГОРИМ АШИГЛАХ ХҮСЭЛТ

Татвар төлөгчийн нэр:

Эцэг (эх)-ийн нэр /иргэний хувьд/:

Нэр /иргэний хувьд/:

Регистрийн дугаар:

Татварын төлөгчийн дугаар:

Харьялах татварын алба:

Хаяг байршил:

Эрхэлж буй үйл ажиллагаа:

Үйл ажиллагаа явуулах хаяг:

Татвар төлөгч ..... –ний татварын хялбаршуулсан горим ашиглах  
хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэнэ үү.

Хавсаргасан баримт:


Хүсэлт гаргасан: ..... / ..... / .....  
Гарын үсэг, тэмдэг ..... нэр ..... огноо



IPAHG26HCGP24BACQDPEREGLAIA



Татварын хялбаршуулсан горим ашиглах  
хүсэлтийг бүртгэх, шийдвэрлэх, бүртгэлэс  
хасах журмын // дугаар хавсралт



Маягт ХГ-02

## Монголын Татварын Алба

### ТАТВАРЫН ХЯЛБАРШУУЛСАН ГОРИМ АШИГЛАХ ТАТВАР ТӨЛӨГЧӨӨР БҮРТГЭХ ШИЙДВЭРИЙН ХУУДАС

Дугаар ...

#### Татвар төлөгчийн:

Нэр:

Регистрийн дугаар:

[REDACTED]

Татварын төлөгчийн дугаар:

[REDACTED]

Харьяалах татварын алба:

[REDACTED]

#### Татварын хялбаршуулсан горим ашиглах татвар төлөгчөөр бүртгүүлэх:

Хүсэлт ирүүлсэн огноо:

[REDACTED]

Хүсэлтийн дугаар:

[REDACTED]

Шийдвэр гаргасан татварын алба:

[REDACTED]

Шийдвэрийн огноо:

[REDACTED]

Хялбаршуулсан горимоор тайлан гаргаж эхлэх  
хугацаа:

[REDACTED]


Хянан баталгаажуулсан:

татварын улсын (ахлах) байцаагч:

..... / .....

Гарын үсэг

нэр





Татварын хялбаршуулсан горим ашиглаж  
хүсэлтийг бүртгэж, шийдвэрлэх, бүртгэлээс  
хасах журмын дугаархавсралт

Маяц ХГ-03

## Монголын Татварын Алба

### ТАТВАРЫН ХЯЛБАРШУУЛСАН ГОРIMOОС ХАСАГДАХ ХҮСЭЛТ

Татвар төлөгчийн нэр:

\_\_\_\_\_

Регистрийн дугаар:

\_\_\_\_\_

Татварын төлөгчийн дугаар:

\_\_\_\_\_

Харьяалах татварын алба:

\_\_\_\_\_

Хаяг байршил:

\_\_\_\_\_

Хялбаршуулсан горимоос  
хасагдах шалтгаан:

\_\_\_\_\_

Татвар төлөгч \_\_\_\_\_ –ний татварын хялбаршуулсан горимоос  
хасагдах хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэнэ үү.

Хавсаргасан баримт:

\_\_\_\_\_

Хүсэлт гаргасан: ..... / ..... / .....

Гарын үсэг, тэмдэг

нэр

огноо

Бүртгэлийн дугаар .....  
**ТАТВАРЫН ЕРӨНХИЙ  
ГАЗАР**  
ХУУЛБАР  
Хуулбар олгосын  
79 78 81  
20 ... оны ... сарын



IPAHG26HCOPE26BAYCQGBR84DULAY



Татварын хялбаршуулсан горим ашиглах хүсэлтийг бүртгэх, шийдвэрлэх, бүртгэлээс хасах турмын 7. дүгээр хавсралт

# Монголын Татварын Алба

Маят XГ-04

## ТАТВАРЫН ХЯЛБАРШУУЛСАН ГОРИМЫН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ ШИЙДВЭРИЙН ХУУДАС

Дугаар ...

## Татвар төлөгчийн:

Нар.

## Регистрийн дугаар:

#### Татварын төлөгчийн дугаар:

Харьяалах татварын алба:

Хялбаршүүлсан горимд бүртгэгдсэн огноо:


Татварын хялбаршүүлсан горимын бүртгэлээс хасах:

#### Шалтгаан, үндэслэл:

#### Шийдвэр гаргасан татварын алба:

ШИЙДЭР ГАРАСАН  
ШИЙЛВЭРИЙН ОГНОО

Хялбаршүүлсан горимоор тайлан гаргах хугацаа:

A horizontal row of 20 empty square boxes, arranged in two rows of ten, intended for handwritten responses.

Хянаң баталгаажуулсан.

татварын үлсын (аҳпах) байлаагч

Гарын усаг / ... /

Гарын чөлөг

НЭР

Бүртгэлийн дугаар ..... 220  
ТАТВАРЫН ЕРӨНХИЙ  
ГАЗАР  
ХУУЛБАР ҮНЭН  
Хуулбар ~~олгосон~~ ажилтны гарын үсэг  
.....  
*Н.С.*  
20.19.оны 12 сарын 31 -ний өдөр

